


Багшлах ур чадварын үнэлгээ ГОРИЛОГЧДОД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ



Зураглал Riikka Hyypä, Unigrafia (2013)

Агуулга

ХУУДАС 2

Сургалтын үнэлгээ
Их сургуулийн багшлахуй ба суралцахуй

ХУУДАС 3-8

Багшийн портфолио
Багшийн туршлагыг харуулсан
үндсэн бүрдэл хэсгүүд
Сурган заах арга барил, арга зүй
Багшилсан туршлага
Сургалтын хөтөлбөр хөгжүүлэлт ба боловсролын
манлайлал
Санал хүсэлт
хавсралтууд

ХУУДАС 8

Нээлттэй хичээл

ХУУДАС 9

Ярилцлага

ХУУДАС 9

Багшлахуй, суралцахуйн туршлагын тойм
- үнэдсэн хэсгүүд



Багшлах ур чадварын үнэлгээ

Ажилд авах эсвэл албан тушаал дэвшүүлэх үйл явцын нэг хэсэг болгон багш танаас өөрийн портфолиоог танилцуулах, нээлтэй хичээл заахыг урих, багшлахуйн чадамжийг тодорхойлох ярилцлага авах зэргээр багшлах ур чадварын үнэлгээг хийнэ. Эдгээрт үндэслэн багшлах ур чадварын үнэлгээний хороо таны багшлах чадамжийн талаар тодорхойлолт гаргаж үнэлгээ өгнө.

Энэхүү багшлах ур чадварын үнэлгээний удирдамж нь танд өөрийн багшийн портфолиогоо шинэчлэн бэлтгэх, нээлттэй хичээл болон ярилцлагад бэлтгэхэд туслах зааварчилгаа юм.

БАГШИЙН ПОРТФОЛИО нь таны багшлах ур чадвар, туршлага, мэргэжлийн өсөлт хөгжлийг системтэй, товч байдлаар харуулж байх ёстой. Багшийн портфолио нь хүүрнэл, эргэцүүлэл хэлбэртэй бичигдсэн байх ба нотлох баримтуудыг хавсаргаж өгсөн байна. портфолиод орох бүрдэл хэсгүүдийн жагсаалтыг энэхүү баримт бичигт жишээ болгон хавсаргав. Эдгээр гол хэсгүүд нь портфолиогын үндсэн бүтэц болох бөгөөд та хэсэг тус бүрийг нухацтай авч үзэн бөглөөрэй.

Багшийн портфолиогын бүтэц

Ерөнхий удирдамж:

- Портфолио нь 5-8 хуудсан багтсан байвал сайн
- Чухал гэж үзсэн нотлох баримтуудыг 6-10 хуудсанд багтаан хавсралтаар оруулна. Үндсэн хэсэгт тухайн хавсралт бүрийг оруулах болсон шалтгааныг бичнэ үү
- Багцыг хүүрнэх эргэцүүлэл хэлбэрээр бичнэ
- Эзэн бие дээр (би, би, миний...)
- Тайлбарыг үнэмшилтэй, найдвартай, үндэслэлтэй болгохын тулд холбогдох бүх ажлын туршлагыг баримтжуулж нотлох баримтаар хангана уу.
- Портфолиод өнөөг хүртэл хүрсэн ололт амжилт, цаг хугацааны явцад хөгжиж ирсэн байдал, цаашдын мэргэжил дээшлүүлэх шаардлагатай чиглэлүүд зэргийг тэнцвэртэй оруулж бичнэ.
- Өөрийн бодол, эргэцүүлэл, **өөрийгөө үнэлгээ ба түүний нотлох баримт зэргийг** оруулж өгнө үү
- Хэрэв та багшийн мэргэжлээр удаан ажилласан бол өнгөрсөн 5-10 жилийнхээ туршлагын талаар танилцуулж, эргэцүүлэл бичиж болно. Гэсэн хэдий ч багшлах туршлагын цар хүрээг харуулахын тулд карьерынхаа туршид заасан бүх хичээлийн жагсаалтыг хавсралтад оруулаарай.
- Портфолио нь шинжлэх ухааны тайлан мэт бичээрэй: ишлэл, ном зүйг зүй зохистой ашиглах

Нүүр хуудас: Таны нэр, огноо, багшийн портфолиогын зорилго, холбоо барих мэдээлэл, Боловсролын зэрэг.

Агуулга: Хуудасны дугаар бүхий агуулгын хүснэгтийг оруулж хавсралтын жагсаалтыг нэмнэ үү. Боломжтой бол багшлахуйн суралцахуй үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн дагуу портфолиогоо бичээрэй.

Албан тушаал дэвшиж байгаа та нэгэнтээ сургуульдаа багшилж байгаа учраас өөрийн багшлахуйн ур чадвар, чадамжаа хэрхэн хөгжүүлж ирсэн талаарх дүгнэлтүүдийг хураангуйлан хэсэг бүрд оруулаарай.

Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар

1. Багшлахуй, суралцахуйн арга, арга зүй

Таны багшлахуй, суралцахуйн арга, аргачлал нь оюутнуудын суралцахуйн үр дүнг дээшлүүлэх талаар таны бодол, ойлголтыг тодорхойлно.

а. Багшлахуй, сургалцахуйн талаар ойлголт

- Багшлахуй, суралцахуйн талаарх таны итгэл үнэмшил, хүлээлт, жанжин шугам, найдвар

б. Та хэрхэн хичээлээ заадаг талаар

- Таны итгэл үнэмшил таны сурган заах арга барилд, сурган заах арга зүйн сонголт, сургалтын үнэлгээ, оюутнуудыг удирдан чиглүүлэхэд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодорхой жишээн дээр тайлбарлан бичих.
- та оюутнуудтай хэрхэн харьцдаг талаар
- таны ашигладаг багшлахуйн арга ба суралцахуйн үнэлгээний талаар

с. Та яагаад ингэж зааж байгаагаа зөвтгөх

- Сурагчдын суралцахуй, сургалтын үр дүнд таны ашиглаж буй арга үр дүнтэй байгааг тодорхой жишээгээр харуулах
- Тунгаан эргэцүүлдэг, тууштай зорилготой гэдгээ харуулах
- Чанартай багшилж буйгаа ямар шалгуураар хэмждэг талаар
- Өөрийн үр дүнтэй багшилж байна гэдгээ хэрхэн ямар шалгуураар үнэлэх тухай
- Багшийн өдөр тутмын ажлаа дүгнэж эргэцүүлдэг байдал
- Таны заах арга барил олон жилийн туршид хэрхэн хөгжсөн, мөн энэ нь сурагчдын суралцахуйн үр дүнд хэрхэн нөлөөлсөн талаар тусгах
- хэрэв таны сурган заах арга нь урлаг уран сайхны туршлага эсвэл үйлдвэрлэлийн туршлага дээр үндэслэсэн бол энэ нь хэрхэн нөлөө үзүүлдэг талаар жишээ болгон бичих

2. Багшлах туршлага

Багшлах туршлага нь их, дээд сургуульд, мэргэжлийн боловсролын байгуулга зэрэгт багшилж байсан туршлага, бакалавр, магистр, докторын оюутан удирдсан, зөвлөсөн байдал зэргийг багтаана. Хэрэв жагсаалт урт бол хавсралт болгон оруулахыг зөвлөж байна.

а. Боловсролын туршлагын хамрах хүрээ(бакалавр, магистр, докторын түвшний боловсрол, насан туршийн боловсрол, мэргэжлийн болон удирдлага, менежментийн боловсрол)

- таны багшилж байсан туршлага, үүрэг хариуцлага. Өөрийн үндсэн үүрэг, оруулсан хувь нэмрийг тайлбарлана уу.
- Үндэсний болон олон улсын бусад боловсролын байгууллагуудад багшилж байсан байдал
- удирдлага, менежментийн боловсролын байгууллага, бусад боловсролын байгууллагад ажиллаж байсан багшилж байсан туршлага
- хичээл/модуль/хөтөлбөрийг заах чиглэлээр бусадтай хамтран ажилласан туршлага.

- Таны туршлагад тулгуурлан олж авсан мэдлэг таны багшлахуйн ур чадвар болон оюутны суралцахуйн үр дүнд хэрхэн нөлөөлж байгаа талаар (ялангуяа та багшлах арвин туршлагатай бол)
- b. Дипломын ажил удирдан чиглүүлэх** (жишээ нь: удирдах, зөвлөх, хянах)
 - Оюутнуудад диссертац (BSc, MSc, PhD), төсөл, бүтээл, лабораторийн даалгавар гэх мэт ажилд удирдан чиглүүлсэн зөвлөгөө өгсөн таны туршлага.
 - Оюутан удирдахдаа ашигладаг арга барил
 - Удирдагчийн хувьд таны хөгжил
- c. Хичээл, сургалтын материалыг боловсруулах, сайжруулах, шинэчлэх**
 - оюутнуудад зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн (сурах бичиг, гарын авлага мультимедиа, бусад) боловсруулах, ашиглах, хөгжүүлэх
 - Эдгээр сургалтын материалыг бэлтгэх, ашиглахдаа сурган заах арга зүйн талаас та юуг анхаарсан болох
- d. Хичээл хөгжүүлэлт**
 - Өөрийн хичээлээ хэрхэн хөгжүүлсэн талаарх нотолгоо, тайлбар
 - Энэ хэсэгт мөн өөрийн багшлахуй, суралцахуйн чиглэлээр бичиж хэвлүүлсэн өгүүлэл, нийтлэлүүд эсвэл боловсрол, сурган заах арга зүйн үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний илтгэлүүд оруулж болно.

3. Сургалтын хөтөлбөр хөгжүүлэлт, боловсролын манлайлал

Сургалтын хөтөлбөр боловсруулан хөгжүүлэх, боловсролын манлайллын үйл ажиллагаа нь хичээлийн хөтөлбөр хөгжүүлэх түүшингээс давсан үйл ажиллагаа, үүрэг хариуцлага юм. Хавсралтуудыг илүүтэй ашиглаарай

- a. Сургалтын хөтөлбөр боловсруулах**
 - Сургалтын хөтөлбөр боловсруулахад таны оролцоо. Хэрэв танд өмнөх туршлага байхгүй бол цаашид энэ чиглэлд ямар үүрэг, оролцоотой ажиллаж хувь нэмэр оруулах боломжтой талаараа бичээрэй.
 - Хөтөлбөр боловсруулах, мэргэжил нээх зэрэгт манлайлан оролцож, удирдан чиглүүлсэн туршлага.
 - тэнхим, салбар, сургууль, их сургууль, үндэсний болон олон улсын түвшинд багшлахуй, суралцахуйг (=боловсролын хөгжил) хөгжүүлсэн эсвэл сургалтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оруулсан таны хувь нэмэр оролцоо
- b. Хөтөлбөрийн удирдагч, тэнхимийн эрхлэгч эсвэл томоохон боловсролын байгууллага удирдаж байсан туршлага**
 - Зөвлөх багш, багш, мэргэжил хариуцсан багш/профессор, багийн ахлагч, хөтөлбөр ахлагч, тэнхимийн эрхлэгч, зөвлөгч, дасгалжуулагч гэх мэт боловсролын манлайллын үйл ажиллагаа.
 - Таны тусламж, дэмжлэг залуу багш, туслах багш, бусад багш нарын багшлахуйн чадамжийг дээшлүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулсан талаар бичих
 - Хэрэв танд өмнөх туршлага байхгүй бол цаашид өөрийн боломжит үүрэг, хувь нэмрийг хэрхэн харж байгаа талаар тусган бичих боломжтой
- c. Сургууль/их сургууль/үндэсний/олон улсын түвшний боловсролын хөгжилд оруулсан хувь нэмэр**
 - орон нутаг, үндэсний болон олон улсын түвшний хамтын ажиллагаатай боловсролын үйл ажиллагаанд манлайллын үүрэг гүйцэтгэсэн байдал.

4. Багшийн хөгжил

Их сургуулийн сурган заах арга зүйн сургалтууд, бусад сургалтуудаар дамжуулан өөрийн багшлахуйн чадамжийг хэрхэн олж авсан, хөгжүүлсэн талаар Багшийн хөгжил хэсэгт бичээрэй. Нотлох баримт, өөрийн эргэцүүлээ оруулахаа битгий мартаарай.

a. Сурган заах арга зүйн чиглэлийн сургалтад хамрагдсан байдал.

- Албан боловсролоор таны олж авсан сурган заах арга зүйн боловсрол: та хэдэн кредит дүүргэсэн, хаана, хэзээ
- бусад сургалтууд эсвэл багшлахуйн ур чадвар, чадамжаа хөгжүүлсэн арга замууд
- багшлахуй, суралцахуйтай холбоотой өөрийн гэсэн тусгайлсан судалгааны ажлууд
- *Жагсаалт урт бол хавсралтыг ашиглах нь дээр.*

b. Сурган заах арга зүйн хичээлүүдээс олж авсан үндсэн мэдлэг, багшлах чадвараа хөгжүүлсэн байдал

- Таны сурган заах арга зүйн боловсрол эзэмшсэн байдал эсвэл багшлахуйн сургалцахуйн чиглэлээр уншиж судалсан судалгааны ажлууд хэрхэн таны багшлахуй ур чадварыг дээшлүүлсэн талаар мөн оюутнуудын суралцахуйн үр дүнг дээшлүүлсэн талаар бичиж болно.
- Та сурган хүмүүжүүлэх ур чадвар, чадамжаа хэрхэн хадгалж, сайжруулж байна вэ?
- та багшийн хувьд өөрийн давуу тал, хөгжүүлэх шаардлагатай чиглэлээ хэрхэн тодорхойлох вэ?
- Хавсралтад та өөрийн төгссөн бүх сурган заах арга зүйн курс, дамжаа, хичээл болон бусад холбогдох үйл ажиллагааны жагсаалтыг хавсаргаарай.

5. Санал хүсэлт

Энэхүү Санал хүсэлт хэсэгт таны хичээлийн хүрээнд ирж байсан санал хүсэлтүүд болон тухайн санал хүсэлтийг хэрхэн ашигласан талаарх мэдээллийг нотолгоотой тайлбарлан бичнэ. Мөн үе хамт олны санал хүсэлт, бусад санал хүсэлт, багшлахуйн ур чадварын үнэлгээ, шагнал, урамшууллын талаар оруулж болно. Жагсаалт урт бол хавсралтад оруулна уу.

a. Оюутны санал хүсэлт; зааж байсан хичээлүүдийн жишээгээр тайлбарлах

- таны хүлээн авсан санал хүсэлтүүд
- Та хичээлээ хөгжүүлэхдээ дээрх санал хүсэлтийг хэрхэн ашигласан бэ?
- Хавсралтад оюутнуудаас авсан хичээлийн талаарх санал хүсэлтийн системчилсэн хураангуйг хүснэгт хэлбэрээр өгвөл зохино. Хавсралтад дараах зүйлсийг оруулаарай:
 - таны зааж байсан хичээлүүд
 - санал хүсэлтүүд цаг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж байгааг хуруулах зорилгоор хичээлүүдийн хүрээнд оюутнуудын санал хүсэлтийн тоон нэгтгэн оруулаарай.
 - нэг хичээлд хамрагдсан оюутны тоо
 - нэг хичээлд санал хүсэлт өгсөн оюутнуудын эзлэх хувь

b. Бусад санал хүсэлт (хамтрагч багш нар, ахлагч нар гэх мэт)

- Өмнөх багшлахуйн ур чадварын үнэлгээ болон түүнээс хойш хэрхэн сайжруулсан талаарх мэдээлэл (заавал биш)

c. Итгэмжлэх жуух бичиг, шагналыг хүлээн авсан байдал

- Таны багшлах чадвараа олон нийтэд хүлээн зөвшөөрүүлсэн байдал.
- Бусад багшлахуйн чадамжийг илтгэх баталгаа, нотолгоо, жишээ (заавал биш)
- бусад гол шалгуурууд

Хавсралтууд

- Портфолиогын төгсгөлд хавсралтуудыг нэмж, дугаарлаж, бичвэрт иш татна.
- Бичвэрт хавсралтын талаар тодорхой бичиж, яагаад эдгээрийг жишээ болгон сонгосон шалтгаанаа тайлбарлана. Энэхүү жишээнүүд нь таны шилдэг болохыг нотлох нотолгоо бөгөөд оюутны сурах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр гаргасан амжилтыг тань харуулах болно.
- Оруулж болох боломжит хавсралтуудын жишээ:
 - Сургалтын үйл ажиллагааны жагсаалт, үүнд заасан хичээл, оюутны тоо, хичээлийн түвшин, кредитийн хэмжээ, жил, харгалзах боловсролын байгууллага
 - Удирдан чиглүүлсэн, зөвлөсөн оюутнуудын жагсаалт, он жилүүд, тэдний бүтээлийн нэр
 - Таны аль нэг хичээлийн хөтөлбөр, агуулгын жишээ
 - Оюутнуудаас ирсэн хичээлийн санал хүсэлтийн системчилсэн нэгтгэл, үүнд санал хүсэлтийн тоо, хичээлд хамрагдсан оюутны тоо, санал хүсэлт гаргасан оюутны эзлэх хувь.
 - оюутнууд, хамт олон болон гаднын түншүүдээс ирсэн нээлттэй эсвэл бусад төрлийн санал хүсэлтийн жишээ
 - сургалтын хэрэглэгдэхүүн/тараах материал, үнэлгээний даалгавар, багшлахуйтай холбоотой бусад баримт бичгийн жишээ.

Дараах жишээ загварууд нь таныг ур чадвар, туршлагаа нэгтгэн дүгнэхэд туслах болно - тэдгээрийг өөрчлөх боломжтой.

ХҮСНЭГТ 1 Багшлах туршлага


Он	Хичээлийн нэр	Их сургууль/байгууллага-улс	Оюутны тоо	Хичээлд оруулсан таны үүрэг: Үндсэн багш, туслах багш, хамтран хичээл заасан, зочин, илтгэгч, гэх мэт...	Хичээлийн ерөнхий мэдээлэл (Заавал үзэх/сонгон хичээл, нийт кредит)
Бакалаврын түвшний хичээлүүд					
Магистрын түвшний хичээлүүд					
Докторын түвшний хичээлүүд					
Бусад (жишээ нь мэргэжлийн болон удирдах ажилтны боловсрол)					

ХҮСНЭГТ 2. ДИПЛОМ УДИРДСАН, ЗӨВЛӨСӨН ТУРШЛАГА


Оюутны нэр	Их сургууль/эсвэл-байгууллага, улс	Дипломын ажлын гарчиг	Таны үүрэг: Удирдагч, зөвлөх, шүүмжлэгч гэх мэт...	Дипломын ажлын ерөнхий мэдээлэл: дууссан (жил), ахиц дэвшил жишээ нь: 80/50/30% гүйцэтгэлтэй
Бакалаврын дипломын ажил				
Магистрын дипломын ажил				
Докторын дипломын ажил				

Нээлттэй хичээл


Сургалтын ерөнхий хэлбэрүүд. Суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, оюутны бүлэг, цаг хугацаа, орон зай, хэрэглэгдэхүүн зэрэг нь сургалт явуулах тохиромжтой хэлбэрийг сонгох, багшлахуй суралцахуйн онцлогыг тодорхойлоход нөлөөлдөг хүчин зүйлүүд юм.



Бие даах ажил



Хос хосоороо хийх дасгал



Багаар ажиллах



Багшийн зааварчилгаатай ажил



Бусад шинэлэг хэлбэр

Нээлттэй хичээлийн үнэлгээ нь дараах зүйлд анхаарлаа хандуулна:

- Сургалтын нөхцөл байдлын түвшин, төлөвлөсөн суралцахуйн үр дүн, сургалтын үйл ажиллагаа
- Оюутнуудтай харилцах харилцаа
- Хэрэглэж буй сурган заах арга, техник
- Нээлттэй хичээлийн үед явуулж буй суралцахуйн үнэлгээ
- Нотлох баримт эсвэл харагдах байдал of **game changer spirit???**

ЖИЧ! Багшлахуйн чадварыг тусгайлсан нээлттэй хичээлийн үеэр эсвэл жинхэнэ хичээл заах явцад үнэлж болно. Албан тушаал дэвших үйл ажиллагааны хувьд үнэлгээ таны өөрийн хичээлийн үеэр хийхийг илүүд үзнэ.

Ярилцлага

Сургуулийн багшлах ур чадварын үнэлгээний хороо таныг ажилд авах, албан тушаал дэвшүүлэн үйл ажиллагааны хүрээнд багшлахтай холбоотой ярилцлага авах болно. Ярилцлага нь та болон үнэлгээний хорооны гишүүд, оюутнууд, тэнхимийн ажилтнуудын хоорондын харилцан яриа юм. Үүнийг нээлттэй хичээлийн дараа эсвэл тусад нь товлосон цагт зохион байгуулах нь дээр байдаг. Ярилцлагын үеэр нэр дэвшигч өөрийн портфолио болон нээлттэй хичээлийн талаар дэлгэрүүлэн тайлбарлах боломжтой.

Багшлахуй, суралцахуйн туршлагын тойм.

Портфолиогын бүтэц

1. Багшлахуй, суралцахуйн арга, арга зүй

- a. Багшлахуй, сургалцахуйн талаар ойлголт
- b. Та хэрхэн хичээлээ заадаг талаар
- c. Та яагаад ингэж зааж байгаагаа зөвтгөх

2. Багшийн туршлага

- a. Боловсролын туршлагын хамрах хүрээ
- b. Дипломын ажил удирдан чиглүүлэх
- c. Хичээл, сургалтын материалыг боловсруулах, сайжруулах, шинэчлэх
- d. Хичээл хөгжүүлэлт

3. Сургалтын хөтөлбөр хөгжүүлэлт, боловсролын манлайлал

- a. Сургалтын хөтөлбөр боловсруулах
- b. Хөтөлбөрийн удирдагч, тэнхимийн эрхлэгч эсвэл томоохон боловсролын байгууллага удирдаж байсан туршлага
- c. Сургууль/их сургууль/үндэсний/олон улсын түвшний боловсролын хөгжилд оруулсан хувь нэмэр

4. Багшийн хөгжил

- a. Сурган заах арга зүйн чиглэлийн сургалтад хамрагдсан байдал.
- b. Сурган заах арга зүйн хичээлүүдээс олж авсан үндсэн мэдлэг, багшлах чадвараа хөгжүүлсэн байдал

5. Санал хүсэлт

- a. Оюутны санал хүсэлт
- b. Бусад санал хүсэлт (хамтрагч багш нар, ахлагч нар гэх мэт)
- c. Итгэмжлэх жуух бичиг, шагналыг хүлээн авсан байдал

Нээлттэй хичээл

- a. Сургалтын нөхцөл байдлын түвшин, төлөвлөсөн суралцахуйн үр дүн, сургалтын үйл ажиллагаа
- b. Оюутнуудтай харилцах харилцаа
- c. Хэрэглэж буй сурган заах арга, техник
- d. Нээлттэй хичээлийн үед явуулж буй суралцахуйн үнэлэгээ
- e. Нотлох баримт эсвэл харагдах байдал of **game changer spirit???**

Ярилцлага

та болон үнэлгээний хорооны гишүүд, оюутнууд, тэнхимийн ажилтнуудын хоорондын харилцан яриа юм